# Багачууд баяртаа

*(Гэрэл зургийн сурвалжлага)*











Саяхан манай гэрэл зургийн сурвалжлагч аймгийн төвийн цэцэрлэгүүдээр явж баяртаа хэрхэн бэлдэж байгааг сурвалжлав.

1. Бэгаасаа үерхэн наадсан Орос, Монгол найзууд хэзээ ч, хаа ч биесээ үл мартана.
2. I дүгээр цэцэрлэгийн аврага дуучин Үржинчимэг баяртаа Эхийн тухай дууг дуулахаар бэлджээ.
3. 20 дугаар цэцэрлэгийн хөгжимчин Шийтэр мандолин хөгжмөөр Бамбаруущ гэдэг дууг тоглож суран баяраа угтжээ.
4. 20 дугаар цэцэрлэгийнхэн баяртаа зориулан сайхан концерт бэлтгэв.
5. I дүгээр цэцэрлэгийн бөхчүүл баяраараа барилдахаар зэхэж байна.

## Хаврын тариалан, төл бойжилтын явц

Аймгийн хэмжээгээр энэ онд 89,6 мянган га-д үр тариа, тариалсан нь өнгөрсөн оны энэ үеэс 10,3 мянган га, 11,9 хувиар өсөж САА, МААМС, ХАА-н нэгдлүүд, бүх тариачдын дунд улсын төлөвлөгөөг давуулан биелүүлэх тэмцэл улам өрнөсөөр байна.

Аймгийн хэмжээгээр бүгд 439,2 мянган мал төллөж гарсан төлийн 97,7 хувь нь мэнд бойжиж байна.

Бойжиж байгаа төлийн тоо өнгөрсөн оны энэ үеэс 30 мянга, 7,7 хувиар нэмэгдсэн байна. Хаврын тариалан, төл бойжилтын явцыг сумдаар үзүүлвэл;

| Сумын нэр | Тариалалт: үр тариа биелэлт | Тариалалт: үүнээс улаан буудай биелэлт | Төл бойжилт: бүх малын төллөлт | Төл бойжилт: төлийн төлөвлөгөөний биелэлт | Төл бойжилт: төл бойжилт | Төл бойжилт: хорогдсон төлийн тоо |
|---|---|---|---|---|---|---|
| Алтанбулаг | 92,5 | 100,0 | 80,3 | 88,9 | 93,4 | 1661 |
| Архуст | 60.5 | 51,6 | 87,3 | 49,3 | 98,7 | 381 |
| Батсүмбэр | 115,4 | 130,0 | 61,4 | 75,5 | 98,8 | 64 |
| Баян | 100,1 | 111,4 | 86.3 | 101,2 | 99,9 | 22 |
| Баянбараат | 100,0 | 101,2 | 86,8 | 96,3 | 99,3 | 111 |
| Баяндэлгэр | 103,1 | 112,0 | 78,2 | 100,0 | 99,6 | 42 |
| Баянжаргалан | 115,1 | 103,1 | 80,8 | 100,5 | 99,6 | 84 |
| Баянзүрх | 95,0 | — | 66,8 | 81,7 | 97,6 | 400 |
| Баянцагаан | 106,6 | — | 83,1 | 102,1 | 99,8 | 38 |
| Баянцогт | 105.0 | 104,0 | 75,0 | 104,3 | 97,2 | 346 |
| Борнуур | 97,9 | 112,0 | 69,1 | 94,6 | 94,7 | 337 |
| Бүрэн | 116,5 | 100,0 | 74,3 | 84,0 | 98,5 | 213 |
| Дэлгэрхаан | 106,1 | 100,0 | 84,6 | 96,6 | 94,4 | 963 |
| Жаргалант | 200,6 | 98,9 | 75,0 | 91,1 | 95,0 | 555 |
| Заамар | 93,2 | 96,5 | 87,4 | 96,8 | 96,7 | 734 |
| Лүн- | 97,4 | 113,5 | 76,0 | 93,9 | 99,0 | 264 |
| Мөнгөнморьт | 98,7 | 117,0 | 69,8 | 81,5 | 84,7 | 1604 |
| Өндөрширээт | 74,0 | 79,7 | 81,0 | 95,8 | 100,0 | — |
| Өнжүүл | 100,0 | 100,0 | 84,1 | 101,0 | 97,7 | 558 |
| Сэргэлэн | 67,2 | 74,2 | 73,3 | 87,4 | 98,7 | 187 |
| Тариат | 92,0 | 94,7 | 86,3 | 106,7 | 98,5 | 223 |
| Угтаал | 102,6 | 102,7 | 83,0 | 111,6 | 97,7 | 444 |
| Эрдэнэ | 104,6 | 134,5 | 73,9 | 100,0 | 97,5 | 398 |
| Эрдэнэсант | 100,0 | 105,4 | 69,7 | 90,4 | 99,5 | 99 |
| Баянчандмань | — | — | 34,0 | 43,9 | 100,0 | — |
| Гачуурт | — | — | 51,0 | 68,6 | 95,6 | 69 |
| Их хайрхан | — | — | — | — | — | — |
| Зуунмод | — | — | — | — | — | — |
| аймгийн дүн | 98,4 | 100,4 | 78,7 | 92,3 | 97,7 | 9897 |

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ТОВЧОО 1965—5—27

## Ноос, мал бэлтгэлийн явц

Аймгийн хэмжээгээр 1964 оны энэ үеэс мал бэлтгэл, бодын хялгас, ямааны ноолуур амжилттай бэлтгэгдэж. хөөврөөс бусад ноосны төлөвлөгөө 0,1—2,9 хувиар даван биеллээ.

Ноос, мал бэлтгэх төлөвлөгөөний биелэлтийг сумдын хувиар үзүүлвэл:

| суурь | сумдын нэр | мах | хялгас | хөөвөр | ноолуур | тэмээний ноос |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Гачуурт | 717,0 | 104,0 | 100,2 | 103,0 | 420,0 |
| 2. | Баянчандмань | 116,3 | 116,6 | 102,0 | 100,4 | 186,0 |
| 3. | Баянцогт | 180,3 | 101,8 | 103,1 | 100,0 | 33,0 |
| 4. | Баянзүрх | 100,1 | 126,5 | 101,9 | 100,0 | 39 3 |
| 5. | Заамар | 113,5 | 102,1 | 103,9 | 100,1 | 32.6 |
| 6. | Сэргэлэн | 102,3 | 101,6 | 100,7 | 102,2 | 39,2 |
| 7. | Угтаал | 115,4 | 102,6 | 106,6 | 100,1 | 21,0 |
| 8. | Баянбараат | 107,3 | 100,1 | 100,1 | 100,3 | 27,9 |
| 9. | Бүрэн | 109,6 | 100,9 | 100,0 | 100,0 | 23,0 |
| 10. | Өндөрширээт | 102,4 | 100,5 | 110,0 | 101,0 | 18,2 |
| 11. | Эрдэнэ | 100,6 | 102,0 | 100,0 | 100,2 | 23,0 |
| 12. | Баянцагаан | 107,5 | 100,5 | 100,1 | 101,7 | 14,9 |
| 13. | Баянжаргалан | 103,7 | 100,6 | 100.1 | 100,1 | 16,5 |
| 14. | Тариат | 100,4 | 101,6 | 100 0 | 101,3 | 17,3 |
| 15. | Баяндэлгэр | 100,1 | 100,0 | 100,3 | 100,4 | 14,6 |
| 16. | Мөнгөнморьт | 100,0 | 101,6 | 100,0 | 100,0 | 5,2 |
| 17. | Архуст | 237,9 | 176,9 | 188,4 | 100,0 | 21,6 |
| 18. | Жаргалант | 79,3 | 108,9 | 100,0 | 100,6 | 189,5 |
| 19. | Алтанбулаг | 100,1 | 101,4 | 96,4 | 102,7 | 41,5 |
| 20. | Баян | 98,5 | 126.0 | 101,2 | 100,0 | 13,6 |
| 21. | Лүн | 95,3 | 100,9 | 102,4 | 100,2 | 30,0 |
| 22. | Өнжүүл | 108,7 | 100,4 | 106 2 | 90,3 | 17,0 |
| 23. | Эрдэнэсант | 96,8 | 100,4 | 104,0 | 100,0 | 18,0 |
| 24. | Батсүмбэр | 113,3 | 100,2 | 95,9 | 90,1 | 343,2 |
| 25. | Борнуур | 96,3 | 102,0 | 100,9 | 91,0 | 41,0 |
| 26. | Дэлгэрхаан | 109,3 | 100,6 | 94,4 | 94,0 | 26,2 |
| | Аймгийн дүн | 103,2 | 105,8 | 100,6 | 100,1 | 23,5 |

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ТОВЧОО 1965—5—28

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анх дугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо,
А.Д.Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

18 дахь жилдээ | №42 (1443) | 1965 оны 6 дугаар сарын 1 | МЯГМАР

# Олон улсын хүүхдийн баяр

Өнөөдөр зургадугаар сарын нэгэн. Өвч дэлхий гоёлоо өмсөж, манай ирээдүй, хүүхэд багачууд баярлалдан наадаж байна. Манай өлгий нутаг эх орны маань өнцөг булан бүрт эх орны зүрх болсон Улаанбаатар хотоос эхлээд хөдөө нутгийн бригад суурь, малчны хотонд хүртэл цөм баяр болж, хүүхэд багачуудын инээн баясах, дуулан хөгжимдөх нь хичнээн бахдалтай.

Хөгжил дэвшил өөд замнаж байгаа орны хүүхэд багачууд, ялангуяа Зөвлөлт Холбоот Улсаар манлайлуулсан социалист лагерийн орны хүүхэд багачууд:

. . . Үүрд мөнх мандаж
байг наран,
Үүрд мөнх цэлмэг байг
тэнгэр,
Үүрд мөнх амьдарч
байг ээжий,
Үүрд мөнх байж байг
би . . . гэж

даян дэлхийд цуурайтуулан дуулаад, тэмцэл ялалтынхаа аранзал улаан тугаа өндөрт намируулан, энх тайвны далбааг цэнхэр тэнгэртэй өнгө хослуулж эв найрамдал, хөдөлмөр,эрх чөлөө, тэгш эрх, ах дүүгийн ёс, зол жаргалыг даян дэлхийд бататган тунхаглаж баярт өдрөө тэмдэглэж байна.

Манай орны өсвөрийн үеийнхэн олон улсын хүүхдийн баярын энэ жагсаалд алтан соёмбот улаан далбаагаа намируулж, цог жавхлантай дуугаараа ая барьж, бүрээгээ хангинуулан бөмбөрөө нижигнүүлэн инээд баясал, дуу хөөр болон оролцож байна.

Манай хүүхэд багачуудыг нам, ардын засаг маань байнга энхрийлэн халамжилж сурган хүмүүжүүлдэг болохоор бидний ирээдүй болсон өсвөрийн үе маань социалист эх орондоо халуун хайртай, улс түмний найрамдал, пролетарийн интернационализмын зарчимд үнэнч байдаг.

Орчин үед манай хүүхэд багачууд тал бүрийн боловсролтой болж эх орондоо социализмын өрнүүн байгуулалтанд гар биеэр оролцогч иргэд болжээ.

Одоо эрдэм мэдлэгийн талбарт ч, тариалангийн уудам талбайд ч, таван хушуу мал сүргийн захад ч, хүчит суурь машины дэргэд ч газар сайгүй аранзал улаан бүчтэй хүүхэд багачуудын баясгалант хөдөлмөр өрнөж байна. Орос оронд мандсан 1917 оны Октябрийн хувьсгалын шууд нөлөөний дор үүсэн хөгжсөн 1921 оны ардын хувьсгал манай ард түмэнд, үр хүүхдэд ийм сайхан тэгш эрх чөлөө, зол жаргалыг авчирч өглөө.

Одоо социалист нийгмийг байгуулж байгаа манай эх оронд эх үрсийн төлөө нам засгаас байнга халамжлан анхаарч, өсвөрийн үеийг тал бүрийн мэдлэгтэй иргэн болгон хүмүүжүүлж байхад, хөрөнгөтөн оронд олон сая хүүхэд багачууд зохих хэмжээний боловсрол олж авч чадах байтугай, өлсгөлөн гуланчлал, ядуурална автан өдөр хоногийг арай хан өнгөрөөж байна.

Социализм, коммунизмын ханагар эх оронд хүүхэд бүрийг халамжлан анхаарч, өсгөн торниулж гары нь ганзганд, хөлий нь дөрөөнд хүргэж хүн болгож байхад, хөрөнгөтөн орны ээрхэг түрэмгийчүүд өмнөт Вьетнам, Бүгд Найрамдах ардчилсан Вьетнам улс, Леопольдвиль нийслэлтэй Конго, Доминиканы Бүгд Найрамдах Улс гэх мэт хэд хэдэн оронд байлдааны усан онгоц, нисэх онгоц, тэнгисийн явган цэргээ явуулж дайны түймрийг шатаан ямар ч гэмгүй номхон иргэд, хүүхэд багачуудын амийг хэдэн арван мянгаар нь бусниулж байна.

Социализм коммунизмын орон, хөрөнгөтөн орны үр хүүхдийн хувь заяа ийм өдөр шөнө шиг ялгаатай байна.

Өвч дэлхийн, хэдэн арван сая ариун цагаан сэтгэлтэй эхчүүд энх тайвны төлөө, хүүхдийн эрхийн төлөө энэрэнгүй ариун тэмцэлд нягтарч, бүх ард түмний үр хүүхдэд эв найрамдал, хөдөлмөр, эрх чөлөө, тэгш эрх, ах дүүгийн ёс, аз жаргал олгохыг хүсч байна.

Манай орны хүндэт эхчүүдийн дуу хоолой ч бүх дэлхийн эхчүүдийн дуу хоолойтой нэгдэн энэ уриаг даян дэлхийд нэгэн адил цуурайтуулж байна.

Манай орны хүүхэд багачууд олон улсын хүүхдийн баярын өдрийг сурлага хөдөлмөрийн өндөр амжилтаар угтав.

Одоо сурагчид анги дэвших шалгалтаа амжилттай өгөөд нийгмийн тустай хөдөлмөр хийцгээж байна.

Энэ жил долоо, аравдугаар анги төгсөх хүүхдүүд улсын шалгалтаа өгч байна.

Энэ хүүхдүүд баяраа онц ба сайн сурлагын амжилтаар угтсан нь мэдээж.

Манай орны хүүхэд багачууд өөрийн орны эрхэм хүндэт зочин ах, эгч, Зөвлөлт Холбоот Улсын баатар огторгуйн алдарт нисгэгч Валентина Николаева-Терешкова, Андриян Николаев нартайгаа хамт олон улсын хүүхдийн баярыг тэмдэглэж байгаадаа бүр ч урамтай байна.

## Баярын цахилгаан

**Баяндэлгэрийн МААМС Шаравдоржид**

Үр тариа тариалалтыг дүнгээр нь 100,4 хувиар үүнээс улаан буудайг 112,1 хувиар биелүүлсэнд танай станцын хамт олонд баяр хүргэж арвин их ургац хурааж, дахин хушуучлана гэж аймгийн намын хороо, АДХ—ын Гүйцэтгэх захиргаа бат итгэж байна.

**Аймгийн намын хороо Дэжид**
**АДХ—ын Гүйцэтгэх захиргаа Жамсран**

# Огторгуйн баатрууд манай оронд зочилж байна

Зөвлөлт Холбоот Улсын иргэн огторгуйн баатар нисэгч Андриян Григорьевич Николаев, түүний гэргий огторгуйн анхны эмэгтэй нисэгч Валентина Владимировна Николаева-Терешкова нар манай оронд зочилж байна.

В В. Николаева-Терешкова Зөвлөлт улсын Ярославль мужийн Масленниково тосгонд 1937 онд төржээ. Валентина Николаева-Терешкова 17 наснаасаа эхлэн заводод ажиллаж эхэлсэн ба 1955 онд өөрийн эх Елена Терешковагийн ажиллаж байсан «Красный Перекоп» гэдэг нэхмэлийн комбинатад шилжин ажиллахын хамт дунд сургууль, тусгай мэргэжлийн сургуулийг гэрээр суралцан төгсжээ.

Тэрээр 20 настайдаа коммунист залуучуудын эвлэлд элссэн ба коммунист залуучуудын эвлэлийн ажилд идэвхтэй оролцож байжээ.

Одоо В. Николаева-Терешкова ЗХУКН—ын гишүүн юм.

В. Николаева-Терешкова хөвөн нэхмэлийн технологийн мэргэжилтэй хүн юм.

1959 оноос шүхэрийн спортоор хичээллэж эхэлжээ. В. Николаева-Терешкова 126 удаа шүхрээр буужээ. В. Николаева-Терешкова Зөвлөлтийн огторгуйн нисэгчдийн сургуульд амжилттай суралцаад улмаар 1963 оны 6 дугаар сарын 16-нд гайхамшигт нислэгээ хийж «Восток—6» хөлгөөр огторгуйд 71 цаг аялж дэлхийг 48 удаа тойрон 2 сая орчим километр зам туулсан юм.

Огторгуйн нисэгч А. Г. Николаев 1929 онд Бүгд Найрамдах Автономит Чуваш улсын Шоршелы тосгонд төржээ.

1950 онд Бүгд Найрамдах Автономит Карель улсад ойн аж ахуйн техникчээр ажиллаж байгаад 21 насандаа Зөвлөлтийн цэргийн албанд татагдаж нисэгчийн сургуульд суралцаад 1954 онд төгсч цэргийн нисэгч болсон юм.

А. Г. Николаев засгийн газрын даалгаварыг сайн биелүүлсэн учир 1961 онд «Улаан таван хушуу» одонгоор шагнагджээ.

А. Г. Николаев 1957 онд ЗХУКН—ын гишүүнд элссэн байна.

Тэрээр нөхдийнхөө хамт огторгуйн нислэгийн сургуулийг амжилттай хийж 1962 оны наймдугаар сарын 11-ний өдөр «Восток—3» гэдэг огторгуйн хөлгийг жолоодон халуун журмын анд нөхөр Павел Романович Поповичийн хамт орчлонгийн уудамд анх удаа удаан хугацааны хамтарсан нислэг амжилттай гүйцэтгэсэн билээ.«Восток—3» 95 цагийн турш 2 сая 600 мянга гаруй километр урт зам туулж дэлхийг 64 удаа тойрсон юм. А. Николаев В. Николаева-Терешкова нарын нислэг коммунистууд дэлхий дээр ч, огторгуйд ч хүн төрөлтний хөгжлийн манлайд итгэл төгс явааг яруу тодоор харуулснаас гадна ЗХУ шинжлэх ухааны аугаа их нээлтийг энх тайвны зорилгоор хүмүүсийн зол жаргалын төлөө ашигладгийг бас дахин тод нотолсон юм.

Манай хүндэт хоёр зочин 1963 онд гэрлэн 1964 оны 6 дугаар сард охин төрүүлсэн билээ.

А.Николаев В. Николаев—Терешкова нар одоо Жуковскийн нэрэмжит Агаарын цэргийн инжнерийн Академд суралцаж байгаа юм.

*Манай сурвалжлагч*

## 100 ХОНОГИЙН ДАЙЧИН ЦУВААГААР

Өндөрширээт сумaнд залуучуудын хөдөлмөр соёлын 2 дугаар 100 хоногийн дайчин цуваа эхлэж ажилласнаас хойш сарын хугацаа өнгөрлөө.

Энэ хугацаанд сумын хэмжээгээр 15—35 насны 110 эвлэлийн гишүүд, залуучууд 10 цуваа болон ажилласан ба цуваaны хугацаанд эвлэлийн гишүүд, залуучууд нэг бүрийн хийж гүйцэтгэх ажлыг тэдний эрхэлсэн ажилд нь тохируулан эвлэлийн үүрээс өгч ажилласан байна.

Ингэж ажилласны үр дүнд тус сумын 48 малчин гишүүд, залуучууд хариуцсан 9118 толгой эх малаасаа хүлээн авах төлийг бүрэн бойжуулж байна.

Цагаан алтны 5 сарын аян, 100 хоногийн цуваагаар залуучуудын 4 бригад, 42 хүний бүрэлдэхүүнтэй гаргаж сумын хөөврийн төлөвлөгөөний 85 хувь, ноолуурын 88,6 хувийг биелүүлжээ.

Мөн цуваагаар хаврын тариалалт дээр залуучуудын цуваа хоерыг гаргаж 50 тонн үр хордуулж, 70 тонн үр цэвэрлэжээ.

Тус сумын аварга анчин Даваажав тэргүүнтэй залуучууд уурхайн худаг 1—ийг гаргаж ашиглалтанд оруулсан байна.

Одоо тус сумын ХЗЭ—ийн үүрээс гишүүд залуучуудын хүчээр нэгдэлдээ бод, бог малын саравчтай хашаа барих цуваа ажиллуулж байна.

Сумын ХЗЭ—ийн үүрээс нийт залуучуудын соёлжилт, хөдөлмөр, гишүүдийн манлайлалд үүрийн товчооны үзлэг хийж, МХЗЭ—ийн Төв Хорооны үзлэгт сайн дүн үзүүлэхээр ажиллаж байна.

*Аймгийн ХЗЭ-ийн хорооны ажилтан Б. Аюуш*

